

**Хорчин монголчуудын дом шившлэгийн  
хэрэглээний өнөөгийн байдал  
(Жигүүртэн болон тэнгэр аргадахуйд холбогдох домын жишээнд)**

**Ван Саруул** 

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль, Улаанбаатар, Монгол Улс  
✉ 33787565@qq.com

**Доржпаламын Мандах** 

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль, Улаанбаатар, Монгол Улс

**Хураангуй:** Хорчин монголчуудын дунд жигүүртэн болон тэнгэр аргадахуйд холбогдох домын хэрэглээний өнөөгийн байдалд тандалт судалгаа хийж үзэв. Тунляо хотын болон орон нутгийн 354 хүнээс судалгаа авч боловсруулалт хийхэд домын соёлын талаар тун тааруу ойлголттой байх бөгөөд домын зарим төрөл, хувилбарууд мартагдсан, огт мэдэхгүй, мөн далд нууцлаг байдалтай байгаа нь ажиглагдлаа. Судалгаанд этнопоэтик онолын “диалогийн арга”-ыг ашиглаж, 15-34 насны залуучуудын дунд анкетын аргаар явуулсан судалгаанд “дом хэрэглэдэггүй”, “огт мэдэхгүй”, “мухар сүсэг” гэсэн хэдий ч “монгол соёлоо өвлүүлэх” хэрэгтэй гэж 63,47% нь хариулсан нь домын соёл мартагдаж байна гэсэн дүгнэлтэд хүргэсэн билээ. Энэхүү судалгааны үр дүнд орон нутагт амьдарч буй малчин, тариачин, сэхээтэн 50-аас дээш насныхантай хөөрөлдөхөд домын зан үйл ил үйлдэгддэггүй ч шившлэг зэргийг хараахан мартаагүй байгаа нь чухал үнэ цэнтэй болох нь тогтоогдож байгаа юм. Харин мартагдсан domuудыг сэргээн сануулж, бичиж тэмдэглэн авсан нь бидний судалгааны нэгэн зорилт биелж байгаа төдийгүй, хил дамнасан монгол угсаатны соёлын өвөрмөц байдлыг монголын адил төстэй domuудтай харьцуулан үзсэн нь дараа дараагийн судалгааны эх хэрэглэгдэхүүн болохуйц ач холбогдолтой болсон. Ийнхүү хил дамнасан монгол үндэстний соёлын түүхийг залуу хойч үеийнхэндээ үлдээж буй нь чухал ач холбогдолтой хийгээд соёлын хүн судлалд хамаарах, нийгэм-соёлын нэгэн орон зайн хүрээн дэх (Хорчин нутагт дахь) домын соёлыг хадгалж, хамгаалах, өвлүүлэн үлдээхэд бага боловч хувь нэмэр оруулж байгаа болно.

**Түлхүүр үгс:** *жигүүртэн шувуу, шаазгай, элээ, шар шувуу, хуй салхи, хур бороо андгай, бөө*

## The Current state of spells and incantations among the Khorchin Mongols (With examples related to birds and sky-pleasing rituals)

Wang Saruul 

School of Culture, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia  
 33787565@qq.com

Mandakh Dorjpalam 

School of Culture, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia

**Abstract:** This study investigates the current state of spell (dom) usage related to rituals for warding off evil, invoking blessings, and communicating with the heavens among the Khorchin Mongols. A survey involving 354 people from Tongliao city and surrounding rural areas revealed that respondents generally possess limited understanding of spell culture. Some forms and variations of spells were confused, unknown, or remained hidden. An ethnographic field survey using the “dialogic method” was conducted, particularly focusing on young respondents aged 15-34. The questionnaire showed that a majority of younger respondents expressed negative attitudes, such as “never use spells,” “completely unaware,” or “superstitious.” Although they verbally affirmed the importance of preserving Mongolian culture, about 63.47% explicitly stated their ignorance regarding the meaning and use of these spells, indicating a significant rupture in cultural continuity among younger generations. However, interviews with villagers aged 50 and above including herders, farmers, traditional healers, and artisans showed that they still vividly recall ritual actions and applications associated with spells, including curses (haraal dom) and incantations for warding off evil (shivshleg). This suggests that spell culture remains alive as a fundamental component of the Mongolian cultural heritage. Furthermore, rediscovering, documenting, and preserving gradually forgotten spells constitute a central value of this research. Additionally, comparative analysis revealed both similarities and distinct differences between the spell culture of cross border Mongols and that of the Khorchin region in eastern Inner Mongolia, laying valuable groundwork for future comparative research. Therefore, studying the spell culture of cross border Mongolian communities should be viewed as crucial for cultural inheritance among younger generations, significantly contributing to preserving and revitalizing collective cultural memory.

**Keywords:** *birds, owl magpie, vulture, little owl, whirlwind, heavy rain, shamanism*

### Оршил

Энэхүү судалгааны гол зорилго мартагдаж гээгдэж буй соёлын өвийг хадгалж, хамгаалах, залуу хойч үеийнхэндээ язгуурын монгол соёлоо өвлүүлэхэд нэгд, өвлөн уламжлагчдын нас өндөр болсон, хоёрт, зарим нэг нөхцөл байдлын улмаас ил гаргахгүй өдрөөс өдөрт биднээс алсраад байгаа домын соёлын хэрэглээ уг

судалгааг хийх хэрэгцээ шаардлагыг бий болгосон. Монгол ардын аман яруу найргийн эртний хэлбэр дом шившлэг, даллага дуудлага, хараал зүхэл гэх мэт нэгэн бүлэг төрөл бий. Энэ нь эртний хүмүүс ямар нэгэн итгэл бишрэлийн үүднээс аман бэлгийн хүчээр амьдралын хүслэнгээ биелүүлэх гэсэн хий хүслийг тусгасан зохиол байжээ. “Монголчуудын эдийн болон оюуны соёлын баялаг сан хөмрөгт домын соёл өвөрмөц байр суурь эзэлдэг. Ардын дом шившлэгийг судалж асан тухайн цаг үед монголын соёлд нийт түвшиндээ коммунист улс төр, үзэл суртлын нөлөө гүнзгий нэвтэрч ихээхэн саад тээг учруулж байсан ...” (Тангад 2020, 10).

Аман түүхийн судалгаа нь нэг талаас нийгэм, соёлын хүн судлалын судалгаа, нөгөө талаас түүхийн шинжлэх ухааны судалгаанд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг шинжилгээ судалгааны томоохон арга зүй гэж үзэж болно. “Аман түүхийг хамгийн энгийнээр тайлбарлавал, бичмэл түүхэнд бичигдсэн, эс бичигдсэн байгаль, нийгмийн түүх, үзэгдлийн тухай ард түмэн оюун ухаандаа цээжилж түүхэн хугацааг туулсаар авч ирсэн үйл явцын тусгал юм. Бичмэл түүх бол нэг ба хэсэг бүлэг хүний үзэл хандлагаар бичигдсэн байдаг бол аман түүх нь тухайн түүх, үзэгдлийг хувь хүний туршлагаар (experience) тайлбарлаж байгаа тайлбар гэж ойлгож болно. Энэ судалгаа нь хаягдаж гээгдэж хоцорсон “далд түүхийг” илрүүлж чаддагаараа хамгийн чухал ач холбогдолтойг онцлон тэмдэглэх нь чухал (Тангад 2018, 12).

Аман түүхийн судалгааны хүрээнд хүмүүсийг ажиглаж байхад судлаачдын олж бүрдүүлсэн эх материал нь тухайн судалгааны нэлээд нарийн, анзаарагдахгүй чухал зүйлсийн баталгаа баримт байх нь олонтаа. “Аман түүхийн судалгаа нь бичигдмэл түүхэн баримт шиг бодит баримт сэлтийг тэр бүр нэхдэггүй нь энэхүү судалгааны салбарын онцлог нь болдог” (Бямбарагчаа 2015, 4-15).

Хорчины онцлог бүхий дом шившлэгийн өвлөгдөл цагийн аясаар гээгдэн мартагдаж буй нь өв тээгч настнууд цөөрч байгаатай бас холбоотой байна. Хэдийгээр хэрэглээ нь хомс, ил бус далд шинжтэй ч хээрийн судалгааны явцад сонирхолтой домууд байгааг илрүүлсэн. Судалгаанд хамрагдагсад голдуу өвөө, эмээ, аав, ээжээсээ л сонсож байсан гэж өгүүллээ. Мөн хорчины нутгийн шинжтэй үг хэллэг гацаанаасаа хамаарч бас өөр өөр байна. Хээрийн судалгааг явуулахдаа аман түүхийн аргыг ашигласан. Дом шившлэг нь монгол аман соёлын “аялгуут бус аман соёл”-ын төрөлд хамаарна. Иймд эл судалгаанд этнопоэтик онолын диалогийн арга илүү тохиромжтой гэж үзсэн. Энэ онолыг гаргаж ирсэн эрдэмтдийн нэг нь Михаил Михайлович Бахтин бөгөөд тэрээр уран зохиолын онол, хэл шинжлэл, соёл судлалын салбарт томоохон хувь нэмэр оруулсан юм. Этнопоэтик онол нь Бахтины дэвшүүлсэн “диалогизм” ба “карнавалчлал”-ын ойлголттой ойр холбоотой бөгөөд текст ба соёлын бүтээл дэх дотоод логик, бүтцийн элементүүдийг харьцуулан судалдаг. Энэ онолыг бид судалгаандаа ашигласан.

Монгол зан заншил, аман соёлын гээгдэлд хорчин монголчуудын ахуй соёлын орчныг ойлгох шаардлага бас урган гарч ирнэ. Үүнд оршин буй газар орон, үзэл суртал, эрхэлж буй аж ахуйтайгаа холбоотой нь харагддаг. Ер хорчин монголчуудын талаар хийсэн судалгаа нэлээд байх боловч домын соёлыг тусгайлан авч үзсэн судалгаа тун хомс байв. “Хорчин монголчуудын дом шившлэгийн онцлог” хэмээх эл сэдэв нь бидний “Хорчин монголчуудын аман соёлын онцлог” сэдэвт соёл судлалын ухааны докторын зэрэг горилж буй диссертацийн нэгэн дэд хэсэгт хамаарна. Иймд

диссертацийн хүрээнд сэдвийн судлагдсан байдлыг дараах байдлаар шүүж үзэв. Үүнд, 1. Аялгуут аман соёлын талаар хийгдсэн судалгаа, 2. Аялгуут бус аман соёл: Үлгэр, домог, оньсого, сацал мялаалга, домын талаар хийсэн судалгаа, 3. Соёл судлалын аспектаар хийсэн зарим судалгаа, 4. Хэл шинжлэлийн талаас нь хийсэн судалгаа, 5. Гадаадад судлагдсан байдлын тойм зэргээс үзэхэд дом шившлэгийн талаар хийсэн эрдэм шинжилгээний ажил ар, өвөр монголд тун цөөн байв. Соёлын биет бус өвийг хамгаалах талаар ӨМӨЗО-ны соёлын бодлогоос үзвэл, сүүлийн 10 жилд соёлын өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох, түүнийг хөгжүүлэх менежментийн үйл ажиллагаатай холбоотой 18 эрх зүйн баримт бичиг байна. Үүнд домын талаар тусгайлан заагаагүй ч Соёлын биет бус өвийг хамгаалах тухай тогтоол 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн БНХАУ-ын Төв засгийн ордноос “Биет бус соёлын өвийг хамгаалах ажлыг хөгжүүлэх тухай санал”-д соёлын өвийг хамгаалах ажил бол түүхийн уламжлалыг батлах ба соёлын хөгжлийг хамгаалж, нийгэм журамт соёлын хүчирхэг улсын хөгжилтийн чухал хүчин зүйл болно гээд, энэ ажлын төсвийн төлөвлөгөө гаргасан. Одоо Тунляо хотын улсын дэсийн биет бус соёлын өв 14 төрөл байх ба өвөр монголын дэсийн биет бус соёлын өв 58 төрөл, хотын дэсийн биет бус соёлын өв 204 төрөл, хошуу дэсийн биет бус соёлын өв 469 төрөл байна. Тунляо хотын улсын дэсийн биет бус соёлын өв тээгч 12 хүн, өвөр монголын дэсийн биет бус соёлын өв тээгч 88 хүн, хотын дэсийн биет бус соёлын өв тээгч 224 хүн, хошуу дэсийн биет бус соёлын өв тээгч 593 хүн байна. Эдгээр тоо баримтыг дурдахын учир нь судалгаанд хамрагдагсдын тоотой хамаатай. Хотын хэмжээнд биет бус соёлын өвийг хамгаалах байгуулга, музей ба үзүүллэгийн орон, дурсгалын газар нийт 16, өв хамгаалах заан сургалттай дээд сургууль 3 байна. Өвөрлөгч нутагт хорчин түмний соёлыг судлах, хамгаалах боломжууд байвч, орчин цагийн техник технологийн хурд, өдөр тутмын амьдрал хөнгөвчлөгдөн, авах мэдээлэл нь хүртэл цахим орчинд бэлэн байх боллоо. Энэ мэт нөлөөнд автсан залуу хойч үеийнхэн уламжлалт соёлоо үл анзаарах болсон нь зарим аман соёлын илэрхийлэл тухайлбал, домын соёл, оньсого таавар зэргийг мэдэх хүн тун цөөн болсон нь судалгаанаас харагдав. Мөн ч сэтгэл эмзэглүүлж байна.

### **Судалгааны арга зүй**

Шинжлэх ухааны судалгааны задлан шинжилж, нэгтгэн дүгнэх, ажиглалт, харьцуулалтын арга, сэдвийн судлагдсан байдал болон хээрийн судалгааны үр дүнг математик статистикийн аргаар боловсруулж, бэлгэдэл зүй, домог зүй, тайлан тайлбарлах, этнопоэтик (угсаатны шүлэг яруу найргийн) онолын диалогизмын (харилцан яриа, ярилцлагын) аргуудыг ашигласан.

### **Судалгааны үр дүн**

Судалгааны ажлын зорилтын дагуу ӨМӨЗО Тунляо хот, орон нутгийн 5 хошуунд 354 хүнээс түүвэр судалгаа авсны 54 нь хөдөө орон нутагт малчин, тариачин, сэхээтэн, өндөр настнуудтай ярилцлага хийв. Хорчин нутаг дахь монгол домын хэрэглээний өнөөгийн байдлыг тандаж үзэхийн тулд эхлээд анкетын аргаар 300 оюутан, залуусаас судалгаа авахад дөнгөж 11% нь хувь домыг бага мэднэ гэж хариулжээ. Анкетын судалгаанд хамрагдагсдын насны байдал 15-34 насны


залуучууд байв. Анкетын судалгаанаас үзэхэд, дийлэнх нь домьг “мухар сүсэг” гэж хариулав. Ийнхүү домьн соёлын талаарх ойлголт тун тааруу, язгуурын монгол соёлоо мартаж гээх, тоохгүй болох зэргээс үүдэж цагийн аясаар устах нөхцөл үүсжээ гэх ойлголтод хүргэсэн болно. Орон нутагт 50-аас дээш насны 54 хүнээс судалгаа авсан. Ер нь дом шившлэгийг заан сургахад орон зай, орчин нөхцөлийн хувьд хэрэгжүүлэх боломж нь хязгаарлагдмал гэж хэлж болох талтай. Үүнд үзэл суртал, харьяалал зэрэг нөлөөлнө. Эл байдал нь энэхүү язгуур соёлын тулгамдсан асуудал болж байгаа юм. Анкетын судалгааг 12 асуулгаар явуулсан. Үүнээс “Танай гэр бүлийнхэн дом, шивлэг хийдэг үү” гэсэн асуултад 300 хүнээс нэг ч хүн хариулаагүй, орон нутагт хээрийн судалгаанд оролцсон хүнээс бүгд хийдэг гэж хэлээгүй, багадаа сонсож байсан тухайгаа өгүүлэв. Эл байдал нь домьн соёл нууцлаг, мартагдаж буй гэсэн дүгнэлтэд хүргэсэн. Харин “Монгол соёлоо өвлүүлэхэд таны оролцоо юу вэ” гэсэн асуултад 191 хүн буюу 63,47% нь “өвлүүлэх хэрэгтэй” гэж хариулсан нь юутай ч монгол соёлоо хамгаалах гэсэн санаа харагдаж байна. “Мэддэг домьн талаар бичнэ үү” гэсэн асуултад 21 хүн буюу 7% нь домьн нэр бичив. Эдгээрээс үзэхэд, домьн соёл хорчин монгол залуучуудын дунд “хэрэглээгүй” болсон соёлын нэг болж харагдаж байна. Судалгаанд оролцогчдын 176 хүн буюу 58.67% нь “мухар сүсэг” гэж хариулсан нь язгуур соёлоо цагийн жамаар, түүхэн нөхцөл байдал, хөгжил дэвшлийн давалгаанд дунд ямар нэг хэмжээгээр алдаж байна уу даа гэсэн таамаг төрж байгаа юм. Гэхдээ энэ бол 354 хүний дунд хийсэн судалгаа юм. Мөн ч нийтийг хамруулж судалгаа явуулах нь нөхцөл байдлын хувьд хүчиртэй байлаа. Докторант миний бие ӨМӨЗО-ны албан ёсны бүртгэлтэй өвлөн уламжлагчийн нэг мөн. ӨМӨЗО-ны соёлын бодлогод соёлын биет бус өвийг хамгаалах тухай заасан. Үүнд нэг өвлөн уламжлагч жилд дөрвөн хүнд заан сургана гэсэн байдаг. Ингээд монгол домьн талаар хийсэн судалгаанд боловсруулалт хийлээ.

- Дом шившлэгийн талаар мэдэх үү
- Дом соёлын нэг хэсэг мөн үү (Мухар сүсэг гэж хариулсан)
- Дом бол соёл мөн, биш, сүсэг
- Танай гэр бүлийнхэн дом хийдэг үү
- Монгол соёлоо өвлүүлэхэд таны оролцоо



*Зураг 1. Хорчины оюутан залуусын дунд хийсэн монгол домьн өнөөгийн хэрэглээний судалгаа<sup>1</sup>*

<sup>1</sup> Эх сурвалж: Тунляо хотын 300 оюутныг хамруулав (2024).



**Зураг 2.** Хорчины оюутан залуусын дунд хийсэн монгол домын өнөөгийн хэрэглээний судалгаа<sup>2</sup>

Ийнхүү хээрийн судалгааны явцад цуглуулсан domuудаас жигүүртэн болон тэнгэр аргадахуйд холбогдох зарим домын талаар энэ өгүүлэлд харьцуулсан байдлаар үзүүлнэ. Чингээд “Домын тухай ерөнхий ойлголтоос үзвэл, өвчин зовлон ирэхэд зайлуулах аливаа нэгэн төвөгтэй үйл явдлыг гүйцэлдүүлэхдээ учрах саад хорыг төвшитгөн хаахад тодорхой дүрслэл, тоо, орон зай, цаг хугацааны тогтолцоонд муу хүчин зүйлтэй эсрэгцэх, эвлэрэлцэхийн тулд үйлдэх хүмүүний зан үйлийн цогцолбор арга юм. Аман уламжлалаар тээгдэн өвлөгддөг түүхэн мэдлэгийн нийгэм соёлын хүн судлалын ухаан болон түүхийн шинжлэх ухаанд бичгийн болон аман түүхээр тодорхойлогддог. Аман түүхийн судалгаа нь нэг талаас нийгэм-соёлын хүн судлалын судалгаа, нөгөө талаас түүхийн шинжлэх ухааны судалгаанд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг шинжилгээ судалгааны томоохон шалгарсан арга зүй гэж болно” (Тангад 2020, 11) гэжээ. Дом шившлэгийн тухай ярихын тулд монгол домог зүйн тухай өгүүлэх нь зүйтэй билээ. “Монгол домог зүйд шүтлэг, гүн ухаан, урлаг, уран зохиол, ёс зүй, мэдлэг ухааны бүхий л салбарын эх сурвалж оршиж байжээ. Домог зүйгээс дом шившлэг, тууль, шидэт үлгэр, хууч домог зэрэг ардын аман зохиолын зүйл үүсвэрлэн хөгжсөн байна” (Дулам 1986, 136). Дом шившлэгийн үг утга товч тодорхой, хэлбэр хэллэг энгийн заримдаа шүлэглэн холбож, заримдаа хүүрнэн өгүүлдэг. Мөрийн үг, бадгийн тоо тэнцлийг анхаардаггүй, гэвч үг цэгцтэй, хэмжээ богино байдаг ба ихэнх тохиолдолд захиран хүсэх байдлаар илэрдэг нь бас онцлог юм. Түүний сайныг зөгнөх үг нь хожимдоо ерөөл магтаал болж хөгжин, мууг зүхэх загнах үг нь хараал зүхлийн шинжтэй болж хөгжсөн байна. Профессор С.Дулам “Хүн... шашин шүтлэг “байгалийн хуулийг хүмүүнчилсэн” бол дом шившлэг, “хүмүүний үйлдлийг байгальжуулсан хэрэг”, ...Ид шид бол түүхэн нөхцөл байдлыг онцгой тодруулагч тусгал юм” (Тангад 2020, 19) гэсэн байдаг. Жигүүртэнд холбогдох домын тухай эл судалгааг үүтгэж шувуутай холбоотой домгийн үүслийн тухайд товч өгүүлье. Профессор С.Дулам “Монгол домог зүйн

<sup>2</sup> Эх сурвалж: Тунляо хотын 300 оюутныг хамруулав (2024).



дүр” хэмээх бүтээлдээ “ертөнцийн үүслийн домогт Хун шувуу алаг мэлхий шороо атган эргэж байхыг хараад Очирваань<sup>3</sup> хэлж санаа өгч ертөнцийг бүтээдэг. Эсвэл хун шувуу ч юм уу шумбагч шувуу ус руу шумбан шороог авч ирсэн тухай гардаг. Үүнээс харвал, буриадууд ертөнцийн үүслийг шувуудтай холбон, тэр тусмаа хун шувуудтай холбож үзээд, хун шувууг хүндэлдэг байсан ба фетишизмийн хувьд өөрийн гарал үүслийг хун шувуу (шувуудтай) холбосон байх магадлалтай юм хэмээн өгүүлснээс үзэхэд монголчуудын жигүүртнийг үзэх үзэл, түүнийг үлгэр домогт дүрслэх сэтгэлгээ түүнээс улбаалаад шувууны өнгө зүс, элдэв үйлдэл, дуу зургийг ажиглан, ил үзэгдэл, далд санаагаа домын арга засалдаа холбон үзсэн байх гэсэн санаа харагддаг билээ” (Дулам 1986, 212) гэжээ. Судалгааны хүрээнд хорчин монголчуудын домын соёлыг хэд хэдэн төрөл дээр судалсан ба үүнээс тус өгүүлэлд жигүүртэн болон тэнгэр аргадахуйд холбогдох домын судалгааг сонгов.

Судалгааны явцад цуглуулсан зарим домьг харьцуулалт хийж үзэхэд, доктор Д.Тангад домын судалгааг эх хэрэглэгдэхүүний талаас нь маш дэлгэрэнгүй судалжээ. Харин хорчинд шившлэгийн талаар өвлөн авсан аман мэдээ байгаа нь тухайн соёлыг хэрэгжүүлэх нөхцөл байдал дөмөгхөн, хөөрөлдөн түгээх боломж нь хомс юм байна. Ингэж хэлэхийн учир нь “би малчин хүн, би тариачин хүн юугаа мэдэх вэ” гэх нь нэгэн бодлын өөрсдийгөө хязгаарлагдмал байдалд оруулсан шинжтэй. Би хорчин хүн, миний бие мөн л дом хийж үзээгүй, хүүхэд ахуй үедээ эмээгээсээ сонссон зүйл л үлдэж дээ. Ингээд жигүүртэн болон тэнгэр аргадахуйд холбогдох домьг хээрийн судалгааны баримтад тулгуурлан ар, өвөр монголын жишээн дээр адил төстэй болон ялгаатай, давуу болон сул талуудад ажиглалт хийж үзэв. Шувуудын өнгийг заасан бэлгэдэл, дом шившлэгүүд байв. Хээрийн судалгааны явцад бас нэгэн олзуурхууштай зүйл байсан нь монгол нөхөртэй хятад эмэгтэй монгол дом мэдэж байлаа. Энэ хүн бол Зарууд хошууны Чавagt гацааны малчин хятад эмэгтэй. Энэ Гөө Ли гэдэг монгол хэлээр ярьдаг хятад хүнтэй 2020 оны 9 дүгээр сарын 22-нд жигүүртэнд холбогдох домын талаар хөөрөлдөв.

Гөө Ли: Би Чавagt гацааны малчин хүн. Хятад үндэстэн болохоор багаасаа хятад ном уншиж, хятад соёл бичиг сурч ирсэн, одоо монгол гэр бүлийн бүсгүй учир хятад үг мэдэхгүй хадам ээжтэйгээ бүр монголоор ярилцдаг болжээ. Жигүүртэнд холбогдсон дом гэвэл бидний багад хятадууд хүүхэд бэлэг дэмбэрэлгүй үг яривал “乌鸦嘴” “хэрээ хэл”-тэй гэж зэмлэдэг байсан. Зарим хүнийг болзсон цагтаа ирэхгүй бол хятадууд “放鸽子” “тагтаа нисгэлээ” гэж уурладаг байжээ.

Саруул: Эндээс үзэхэд, дээрх хоёр жигүүртэнд холбогдох зүйр үг дом биш ч гэлээ одоогоор бол төв газарт төдийлөн хэрэглэдэггүй бас л мартагдаж яваа зүйр үгс учир тэмдэглэн үлдээж байгаа билээ.

<sup>3</sup> Очирваань нь 10 хангалын нэг бөгөөд монголоор “Очир баригч” гэдэг. Монголчууд эр зориг, хүч чадал хайрлагч, монголыг даасан ядам бурхан хэмээн дээдлэн шүтэж ирсэн төдийгүй Чингис хаан болон Автай сайн хаанаа Очирваанийн хувилгаан гэж үздэг байжээ. Зүрхэн тарни нь “Ум базар вааний хум пад” болой. Очирваань нь хар өнгийн лагшинтай, 3 мэлмийтэй, хүчирхэг дуутай, хөмсөгнөөс нь гал бадарсан, баруун мутартаа гурван орныг номхотгох буман нарны гэрэл бадарсан 5 хорыг дарах, 5 билиг төгс таван салаа очир, зүүн мутартаа цалам барьсан байх агаад бадамлянхуа дээр заларсан байдаг.

Саруул: Голоо<sup>4</sup>! Жигүүртнээс хэрээ, тагтааг одоо хорчин монголчууд юу гэж үздэг юм бол?

Гөө Ли: Хэрээг муу муухайн бэлэг тэмдэг гэж, хэрээ цугларсан газар сайн учир байхгүй гэдэг. Харин тагтаа цагаан өнгөтэй, бас энх тайвны бэлэг тэмдэг гэж хорчин монголчууд “тагтаа минь нисээрэй, нисээрэй” гэж дуулдаг. Үүнийг ажихад тагтааг сайны бэлгэдэл болгож, хэрээг муушаах үзэл нь монголчуудад ижил байна.

Саруул: Яг энэ мэт бусад амьтанд холбогдсон домүүд байна уу?

Гөө Ли: “Мань насны хүмүүс дом хийдэггүй, яг амьтанд холбогдсон үг яриа бол олон байна. Гэвч ийм яриа нь дом уу, хараал уу, цээр үү бид ер мэдэхгүй. Тухайлбал, ямар нэгэн юманд эрдэм чадал хүрэхгүй хүнийг гурван хөлтэй муур (三脚猫) гэнэ. Бас тэгээд яагаад гурван хөлтэй муур гэвэл мэдээж эрхтэн дутуутай адил мэдэх, чадах зүйлээр дутуу гэсэн санаа байхдаа. Муур хурдан гүйдэг амьтан. Бас хурдан түргэн бодож сэтгэж чадахгүй гэсэн үг юм уу даа” гэв. Ингээд бид хоёр цааш нь тариалангийн соёлд холбогдох домын талаар хөөрөлдсөн билээ.

Монголчуудын хувьд **ууль** шувууны талаарх үзэл “Бэлгэ дэмбэрэлгүй шувуу”, “хар ёрын мэдээ хүргэгч”, “эрлэгийн элч” гэх мэтээр ад шоо үзэх явдал бий. Иймдээ ч “Ууль дуугарвал уршигтай” гэж дууг нь сонсмогц эгдүүцдэг. Хорчин монголчууд ууль дуугарахыг “муугийн чимээ” гэж “Сайн хэл, сайн хэл, дом дом” гэж шившээд:

*“Хүүр сахиж хөдөө хэвт гэснээс биш  
Хүмүүнтэй ойртон хот тойр гэсэн үү  
Нүд чинь сохорсон бол үйл чинь тэрээ  
Нүгэл хураасан бол хохь чинь тэрээ  
Инээсэн ч уйлсан ч ичих нүүргүй чамайг*

*Ойшоох хүмүүнгүй түй түй түй”* гэж нулиман шивэртэй оймс шидэж дом дарлага болгож үргээн хөөдөг байжээ.

Ар хорчины хойд хэсэгт ууль дуугарвал учир явдал харш болно гэж гэр болон модонд улаан бүсээр багласан даавуу тавин дом дарлага хийдэг. Зарим хүмүүс шууд давс цацаж, гай барцад ирэхээс урьдчилан сэргийлж, ганга өвс шатаах, хаалганы хавьцаа хавчуулах зэргээр домнодог байжээ. Ар монголд ууль дуугарахад “Ухны гүзээнд ус аваад ирээрэй, уулийн толгой чаная” (Сампилдэндэв 1987, 38) гэнэ. Иймэрхүү зан үйл, сэтгэлгээ нь эртнээс л байсаар ирснийг “Хавт Хасар”-ын түүхэн үлгэрт ч тусгагдсан байгаагаас харж болох юм. Тухайлбал, Чингис хаан Монь уулын молцог хошуугаар ан хийж явтал өмнүүр нь ууль хэдгэнэ дуугарч өнгөрөхөд эзэн хаан эгдүүцэн

- Энэ ууль шувууг харва гэж Хавт Хасарт хэлжээ. Хавт Хасар нумаа тэлж харвахад хажуугаас нь нэг шаазгай нисэн орж ууль нь зугтаан зайлж гэнэ. Чингис хаан хилэгнэж

- Чи бэлэгт шаазгайг алж, ёрт уулийг зугтаалгалаа гээд Хавт Хасарыг зуун хоног хуурай худагт хорьжээ (Хорлоо 2004, 90). Энэ бол монгол үлгэрийн уран

<sup>4</sup> Хорчинд өөрөөсөө дүүмэд хүнийг элгэмсүү байдлаар хандаж хэлдэг үг.



дүрслэл харилцан нэг нь нөгөөгөө баяжуулж байдаг нийтлэг шинжийг харуулсан байх ба ид шид үйл явдлын зангилаагаар жинхэнэ домог яриаг буй болгосон ажээ” (Хорлоо 2004, 90). Энд домог, магтаалыг дэлгэрэнгүй авахын учир нь монгол аман соёлын өнцгөөс нь судалж буйн жишээ юм. Энэхүү домогт мөн л ууль шувууны уршгийг харуулжээ. Ер нь “Дом шившлэгийн өвөрмөц тал нь нэгд, товчхон, хоёрт, зүйрлэл, чимэглэл, давуулал, хэтрүүлэл, давталт, дүрслэлийг оновчтой хэрэглэсэн өвөрмөц хэв шинжтэй байдаг” (Яан Баяр 2005, 29).

Дээр үзүүлсэн хоёр домоос үзэхэд, эхнийх нь захирч, зүхсэн шинжтэй, дараагийнх нь товчхон бөгөөд өгүүлэмжийн хувьд өвөрмөц байна. Ухна гэдэг ямаан сүргийн дотор сүрлэг амьтны дүрээр илэрхийлж, уулийн толгой чаная гэдэг нь муу зүйлийг цаашлуулах санаан дээр үргээх санааг илтгэжээ. Одоо хараацайд холбогдох домоос сонирхуулья.

*“Хорчин хүүхдүүд хараацай шувуу нисэн ирэхэд*


*Хавар бол уу лаа харийя цай (хараацай) ирээлээ.*

Үүр барилаа өндөг төрүү лөө” гэж хамтдаа шивнэлддэг. Энд дурдсан хорчин нутгийн аялгууг төв халхын монгол хэллэгт буулгавал, “Хавар боллоо, Хараацай ирлээ, Үүр барилаа, Өндөг төрүүллээ” гэнэ. Хараацай бол тал нутгийн хань шувуу гэдэг. Хараацай гэрт нисэн орж байшингийн адарт үүр барьдаг учир хүүхдүүд ингэж шивнэдэг байсан. Хорио цээрийн хувьд үзвэл, гэрийн адарт<sup>5</sup> барьсан хараацайн үүрийг эвдэж болохгүй. Хараацай цонхоор нисэн орж ирвэл зочин ирнэ гэж гэрээ цэвэрлэдэг байжээ. Хараацайн үүрийг (掏窩 Тао wo) уудалж болохгүй, могой амаар чинь орно гэж цээрлэдэг байсан гэдэг. Хорчин нутагт хараацайн үүр эвдэж бусниулахыг цээрлэхийн бас нэгэн учир нь хацар дээр “үү” гарна гэж цээрлэдэг. Эндээс үзэхэд, жишээ нь “үү” гарна гэдэгт итгэх нь хэзээ нэгэн цагт, хэн нэгний үйлдлийн хариуд ямар нэг өөрчлөлт буюу “үү” гэгч гарсан бол түүнийг “үүнээс боллоо”, “түүнээс боллоо” гэсэн таамагт итгэх, нөгөөтээгүүр, эл байдал нь ардын дом, цээрийн ёс болж орчин тойрноо ойлгож мэдрэх, амьтныг хайрлах, байгаль хамгаалах арга ухааныг олгож байсан ажээ. Хорчин нутагт хэрээ, шаазгайн үүрний модоор түлш хийхийг цээрлэх ба элээ алахыг цээрлэдэг. Ар монголчууд хэрээ дуугарахад “Сайн хэлээ нааш нь, Муу хэлээ цааш нь, Гурван зуу настай, Гурван цагаан өндөгтэй болоорой” гэж цээрийг ерөөлөөр эерүүлэх ухаанаар домнон хэрээг харааж зүхэх бус урт насалж, өсөж үржих талаас нь бэлгэджээ. Этнопоэтик онолын үүднээс үзсэн ч угсаатны шүлэг яруу найргийн нэгэн хэлбэр талаас харвал, дээрх “дөрвөн шад” нь дом шившлэгийн “үг цэгцтэй, хэмжээ богино” байх гэсэн онцлог шинжийг илэрхийлжээ. Монголчууд амьтан, шувууны үүр, савыг үл гэмтээх, түүнд холбогдох зан үйл, ая эвийг нь олж аль болох эсэргүү байдлаар зохицуулах арга ухаан, аман билгээрээ дүрслэн илэрхийлдэг онцлог соёлыг бүтээсээр ирсний жишээ ч энд харагдаж байна. Үүнийг тэмдэг зүйн аргаар илэрхийлсэн жишээг элээ андайн домоор үзүүлье. Хорчин монголчууд элээг “ад” гэж үзэж элээ хайчилж шатааж үнсийг нь уулгах буюу усанд хийж цацах зэргээр өвчтэй хүнд дом заслага хийдэг. Энд домын хэрэглэгдэхүүн нь элээн дүрсийг хайчилдаг. Эл хайчилбар


<sup>5</sup> Хорчинд “Адар” гэдэг нь байшингийн дээврийн завсрын хэсэгт байх жижиг онгорхой хэсгийг хэлнэ.

домд таван элээ, долоон элээ, есөн элээг эр, эм хүйс ялгалтай байдлаар хайчилна. Монголчуудын сондгой тоог эрхэмлэдэг заншил нь хорчин монголчуудын зан үйлийн соёлд хадгалагдаж, монголчууд ашдын гурван бэлэг дээд есөн бэлэг гэж цагаан өнгө зүсэм өрөөсөн сондгой тоог эрхэмлэдэг (Хүрэлшаа ба бус. 2005, 465). Бөө мөргөл хорчин монголчуудын зан үйл, ёс заншилд нөлөөлсөн. Есийн тоог онц чадалтай гэж ес есөн тэнгэр хувааж бөө нар есөн толь зүүдэг. Хорчинд бол монгол эм эмнэлэг хөгжиж хүрээ хошууны монгол эм нь улсын дэсийн биет бус өв болж, монгол эмийн үрлийн тоо сондгой тоогоор таван үрэл, долоон үрэл, есөн үрэл гэх мэтээр хэрэглэгддэг. Элээнд холбогдох домын хэрэглэгдэхүүн нь цаас, хайч, аяга, ус сэлт болж, дүрслэлийн хувьд эр, эм арга билэг, ур урлахуйн эрдмийн хувьд хайчилбар байдлаар хийсэн дом нь жигүүртнийг хүншүүлж, өнгөний бэлгэдлийн хувьд монголчуудын сайны бэлгэдэлт цагаан өнгөөр илэрхийлсэн нь хар бараан үйлийг цагаан цайруу үйл болгоход чиглэсэн дом заслага хэмээн тайлж болохоор байна. Энэхүү домд элээг гар барилцсан хүмүүсийн дүрээр илэрхийлжээ. Эл домыг хорчинд андайд хэрэглэдэг. “Андай” бол дуулах, бүжиглэх, дэвсэхийг уялдуулсан урлагийн хэлбэр болно. Мөн ч ард олны урт хугацааны амьдрал тэмцлийн дунд урлаг соёлоо баялагжуулж, өвчин тахлыг засах оюун санааны эмчилгээнд үндэстний зан заншлын нэг хэлбэр болсон байна (mongol.cri.cn).

Андайн домд элээ дүрстэй хайчилсан цагаан өрөө тасалгаа бүхий гэр хэрэглэж, бөө нар цагаан элээ маягийн хувцас өмсөнө. Үүнийг дараах зургаар үзүүлье.



*Зураг 3. Цагаан элээн дүрс бүхий домын зураг*



*Зураг 4. Цагаан элээн дүрсээр хайчилсан цагаан өрөө бүхий гэр*



*Зураг 5. Цагаан элээ хэмээх бөөгийн хувцас*

Элээ бол нүд хурц түргэн хөдөлгөөнтэй маш өндөрт нисдэг махчин шувуу, элээ нялх төлийн дээр сүүдрээ тусган бээрүүлж, нялх төлийг дагжин чичрээд тэнцэж чадахааргүй болгож байгаад шүүрдэг. Иймээс ардын аман ярианд “Элээ элээ эргэн дээр, ишиг хурга зүлгэн дээр”, “Элээ элээ эргэнэ, ишиг хурга өргөнө” гэлцдэг. Хорчинд мал төллөх цагаар элээ харагдвал “Элээ хулгайч гөө гөө”<sup>6</sup> гэж хэдэн удаа шившдэг байсан гэдэг.

Хорчинд шар шувуунд холбогдох ийм нэг дом байна. Шар шувууг ад чөтгөрийг үлдэн хөөдөг шидэт шувуу гэдэг. Шар шувуу ам будаа сүйтгэдэг хулгана, могойг иддэг. Иймд хүрээ андайд:

<sup>6</sup> Жигүүртнийг хөөж айлгахдаа “гөө гөө” бас заримдаа “гөөш гөөш” гэх нь хол зайл гэсэн утгатай үг юм.

*“Зажин үсэн замагтай  
Жавар салхи хөлөгтэй  
Хөндэй модон хэвтэштэй  
Хий салхи хөлөгтэй  
Хотгор газар хоногтой  
Хуй салхи эргэлэгтэй  
Хулгана оготно идэштэй  
Хорт могой зууштай  
Харанхуй гилсах хараатай  
Харгана буралж замтай  
Эцэг тэнгэрийн элч*

*Элээ адын дарлага”...* (Хүрэлшаа 2012, 76) гэдэг. Хүмүүс ууль шувуу элээ адыг хөөнө гэж шүтэж байсан ч тэр нь орой шөнөөр муухай дуугарч хүмүүсийг цочоодог учир муу ёрын тэмдэг гэдэг. Андай үдээх эхлэлтэд:

*“Шар ууль хувираад чи саравч барин донгодох чинь юу вэ?  
Цаанаас чиний дохиодсон шалтаг учраа хэл дээ  
Хар уульд хувираад чи хамгийг цочоох учир юу вэ?  
Харишил зовлон сэдсэн гол учраа ярь даа”* гэж домнон дуулдаг байжээ.

Зарууд хошуунд хийсэн хээрийн судалгаагаар Өлзиймөрөн гацааны бүсгүй Ин Шиаотай ярилцав.

Ин Шиао: Шувуун тухай дом багадаа л сонсож байсан. Жишээ нь, Тал дээр Таг шувуу (хар хэрээ ирвэл тааг тааг талыг барна. Тарган ээ (хорчин монголчууд өтлөө эмгэн ээжийг ээ гэж дууддаг) будааг барна гэж тааг гэж хар шувууг хэлж байжээ. Хорчин монголчууд бас шаазгай дуугарвал сайн явдалтай гэх бөгөөд шаазгайн тухай:

Шаазгай шаг, шагай бог  
Өндөр сүүлтэй одгоно<sup>7</sup> бог  
Худуу жээ жээ нь гэрийн ард  
Сүүлээ гэсэн туулай хүү (Зоригт ба бус. 2017, 328) гэж шивнэж байжээ.

Жигүүртэнд холбогдох домын талаар хээрийн судалгааны явцад цуглуулсан дом, шившлэгийг дүгнэж үзэхэд хорчин монголчуудын дунд өдгөө цагт домын хэрэглээ хомс болсон ч хүмүүсийн санаанд үлдэж хадгалагдаж яваа дом байгаа нь ажиглагдав. Гэхдээ энэ нь тийм ч нийтлэг бус. Уулзаж ярилцсан 54 хүн голдуу багадаа сонсож өссөн тухайгаа ярихаас бус яг одоогоор хэрэглэж буй гэж огт хэлсэнгүй. Тэдний хувьд уулзсан хүн бүр “бид юугаа мэдэх вэ” гэж хариулж байсан ч удаан ярилцсаны эцэс харин сонирхолтой домоудыг ярьж байлаа. Тэдний ярьж байсан домоудыг бичиж тэмдэглэн судалгааны эргэлтэд оруулж байгаа нь бидний судалгааны ажлын нэгэн зорилт биелэгдэж, хойч үеийнхэндээ үлдээх аман соёлын өвийг хадгалж, хамгаалах чухал үнэ цэнт ажил болов. Энэхүү судалгаанд жигүүртнийг тэнгэр аргадахуйтай холбон үзэж байгаа нь санаандгүй зүйл биш ээ. Монголчууд сав, шим ертөнцийн юмс үзэгдэл түүний зүй тогтлыг сайтар ажиж дөрвөн цагийн эргэлтэд түүнд зохицон амьдарч ирсэн ард түмэн билээ. “Тэнгэр

<sup>7</sup> Цагаан өнгөтэй жижиг биетэй хулганыг хорчинд одгоно гэнэ

аргадах хэмээх ойлголт нь байгалийн дийлдэшгүй хүчин зүйлсийн өмнө хүн хүчин мөхөсдөх учир амь бие, адгуулж буй малаа хамгаалахын төлөө хийж ирсэн бүхий л зан үйлийн үр дүнд буй болсон монголчуудын нэн өвөрмөц нууцлаг арга ухааны үнэт соёл юм” (Тангад 2020, 32). Хорчин нутагт “зун цагт шаага (шагай) наадвал мөндөр орно” гэлцдэг. Хорчинд түгээмэл оршдог нэгэн шившлэг бол нар үүлний цаагуур орвол хүүхдүүд “нар нар наашаа, нарны сүүдэр цаашаа, бөө бөө хайлах, бүжин туулай дэгдээрэй” гэдэг байжээ. Үүтэй төстэй түгээмэл мэддэг бас нэгэн шившлэг бол бороо орж байхад хүүхэд гадаах байдлыг харж: “бороо бороо орж байна, бурхан ширээ хөдөлж байна, анга<sup>8</sup> анга (өөрийн дүү, хүүхэд) уйлж байна анга, мөөмөө<sup>9</sup> нь сандарч байна гэж шивнэдэг. Энд анга гэх үг нь манж үг, мөөмөө гэдэг нь ээж гэсэн хорчин хэллэг юм. “Анганы мөөмө сандарч байна” гэх үгийг Өвөр монголын хошуу нутагт өөр өөрөөр хэлдэг. Хүрээ хошууныхан “Анганы мөөмө сандарч байна” гэж хорчинтой адилхан хэлдэг. Харин Зарууд хошуунд авгай жээ жээ нь саатуулж байна гэж шившдэг, “Авгай жээ жээ нь саатуулж байна” гэсэн нь хорчин хэллэгээр бол аавынх нь охин дүүг хэлнэ. Энэ шившлэгээс үзэхэд хорчин домын соёлын өвөрмөц тал харагдаж байна. Мөөмө гэдгийг хүрээ хошууныхан ээжийг хэлдэг бол жээ жээ гэдгийг зарууд хошууныхан эгчээ гэдэг. Эдгээр шившлэгээр нутгийн аялгууны өвөрмөц байдал илэрч буй нь харагдана.

Дээр бид хур бороонд холбогдох домын талаар үзэхэд нутгийн аялгуу, мөн манж үгийг нутагшуулан хэрэглэж ирсэн соёл хоорондын харилцааны онолоор бол соёлын уусах хийгээд нэвчих чанар илэрч байна. (Ер нь хорчины соёлд хошуу, гацааны үг хэллэгийн өөрчлөлтөөс гадна манж, хятад хэлний хэрэглээ их байдаг. Үүнийг диссертацид дэлгэрэнгүй тусгасан) Байгалийн нэгэн үзэгдэл хуй салхины талаар ийм нэгэн сонирхолтой дом байх ажээ. Хуй салхинд чөтгөр, шулам элдэв муу хий сүнс явдаг гэх ба хорчинд салхины эрчилж эргэхийг зөв, буруу эргэлттэй гэлцэнэ. Тухайлбал, зөв эргэлттэй хуй салхи хоргүй, буруу эргэлттэй хуй салхийг хортой гэх мэтээр ярьдаг байж. Буруу эргэлттэй хуй салхийг дундуур нь чулуугаар цохивол дуу гарч, сэлмээр цавчвал цус гарна гэсэн ойлголт эрт цагаас уламжилж ирсэн гэдэг. Зарууд хошуунд үдийн өмнөх хуй салхинд “сахиулсан” үд дундын хуй салхинд “бурхан” явдаг, үдээс хойших хуй салхинд “чөтгөр” явдаг гэж үздэг гэнэ. Тэгээд хуй салхи дэгдэх үед:

*“Заамны захаар гар*

*Заадуу<sup>10</sup> (闸刀 Zha dao) боодууд<sup>11</sup> (宝刀 Bao dao) дайрагдаа*

*Захны гадуур гар*

*Жаврын уруу хийс*

*Хол зайл, хол зайл*

*Хожгор эмийн хормой доогуур шурга*

*Түй түй түй ...гэж шившдэг ажээ. Мөн хорчин Зүүн гарын дунд хошуунд:*

*“Хуй чөтгөр, хуй чөтгөр*

*Холхон цаашаа зайл*

<sup>8</sup> Анга гэдэг нь “angai” гэсэн манж үг бөгөөд хүүхдийг өхөөрдөж дуудахад хэрэглэдэг.

<sup>9</sup> Мөөмөө гэдэг нь хорчин үг. 妈妈 “mama” буюу ээж гэсэн хятад үгийг хорчинд мөөмөө гэнэ.

<sup>10</sup> Өвс хэрчих хутга.

<sup>11</sup> Ногоо мах, хэрчих хутга.

*Наашаа ирвэл*

*Хурц сандуу<sup>12</sup> (三刀 San dao)- гаар*

*Хөлийн чинь тас цавчъя...*” гэж шившдэг байжээ.

Энэхүү шившлэгт чөтгөр хэмээх нүдэнд үл үзэгдэх нэгэн дүрийг эрчилсэн хүчтэй салхиар төлөөлүүлж иртэй мэсээр дарах гэсэн хийсвэр санаан дээр тулгуурлан юмшуулал хийж хараан зүхсэн байдлаар илэрхийлжээ. Түмэн бодисын түгээмэл үзэгдлийн нэг цахилгаан цахих үзэгдэл түүнийг хариулах дом шившлэгийн талаар үзвэл:

Монголчууд тэнгэр дуугарч цахилгаан цахихад “тэнгэр эцэг”, “бурхан тэнгэр” хэмээн сүслэн дээдэлж, тэнгэрийн сүр хүчнээс эмээн залбирч явдаг ард түмэн. Аянга цахилгаан нь давагдашгүй хүчин зүйлийн нэг. Тухайлбал, Хорчин нутагт аянгад цохиулсан хүнийг тэнгэрт гологдлоо гэж үзэж бөө залан дом дарлага хийлгэдэг байжээ. Залагдаж ирсэн “тэнгэр дуудагч” буюу бөө нь ихэд л уурласан янзтай:

*“Ерэн есөн тэнгэрийн аль тэнгэр нь буусан юм?*

*Атаат тэнгэр аав минь ач үрээ ингээж зовоох чинь юу юм вэ?*

*Бороо хур оруулахаараа оруулаа, буухгүй газар бууж бүгд олныг үймүүлдэг нь юу юм вэ?*” гэхэд дом хийлгэж буй хүмүүс мал сүргээ ийш тээш нь хөөж туудаг байжээ. Тэгээд домын энэ зан үйлийг хийж дуусаад аянгад цохиулсан хүнийг урагш хандуулан сөгтгөн<sup>13</sup> оршуулдаг зан үйл байсан. Хорчинд цахилгаан цахиж, бороо орохтой холбоотой дараах domuуд байна. Хорчин монголчууд анхны бороо ороход:

*Өндөр хөх тэнгэр минь өлзий хишгээ хайрла суу.*

*Зунаа наашаа, зудаа цаашаа, хураа наашаа, хуйгаа цаашаа, нойтоноо буулгаж,*

*Ногоогоо ургуулбаас, чийгээ буулгаж, цагаагаа дэлгэрүү суу* хэмээн сүслэн гадаа сүү, цагаагаа өргөнө. Эл байдал нь тэнгэр аргадахуйн нэгээхэн зан үйл шившлэгийн хамт хэрэглэгдэхүүнээр биежиж буй нь харагдана. Монгол угсаатнуудын дунд тэнгэр аргадах дом өөр өөр хэллэгтэй байна. Тухайлбал, Урианхайн чонод омгийн хүн тэнгэрт нэргүүлсэн хүний дэргэд:

*“Өндөр гэвэл уулыг ниргэ*

*Өргөн гэвэл талыг ниргэ*

*Өнөр гэвэл (эсвэл өнчин) намайг ниргэ*

*Дэлүү идсэн бол дэлбэ ниргэ*

*Сархинаг идсэн бол салба ниргэ* гэж хашхирдаг байна.

*Хариад шарнууд омгийн хүн тэнгэр дуугарахад”*

*Хан цагаан ястай билээ*

*Хариад буриад омогтой билээ*

*Хав загасны мах идээгүй билээ*

*Хай хэг! хай хэг!* гэж бархирдаг байна. Энд бид шившлэгийн талаас харьцуулж үзэхэд нутаг нутгийн онцлог харагдахаас гадна зан үйл хийж буйгаараа хорчины

<sup>12</sup> Өвс хаддаг хадуурыг хэлнэ. Эдгээрийг хавсралтад зургаар үзүүлэв.

<sup>13</sup> Бохируулан суулгаж оршоохыг хэлнэ.



дом өөр байна. Доктор Д.Тангад эх хэрэглэгдэхүүний талаас нь судалсан нь: Тухайлбал, “Хур бороо орохгүй үед тэнгэр өөд хоргол цацах нь бий” гэжээ. Энэ мэтээс үзэхэд монголчуудын байгальтай харьцах арга ухаан, мөн сүслэх шивших нь өөр өөр байна. Хорчин монголчууд тэнгэр тахиж хур бороо гуйдаг байв. “Сүлдийн сан тальбих” гэж сум хөвчөлсөн нумыг дүрэлзэж байгаа галын хэлбэртэй болгож хөх бүсийн далбаа дарцаг намируулан босгож сан тальбин идээн ундааны дээж өргөн хийморийн дарцаг мандуулж даатгал даллага хийдэг байв (Боржигон Гомбожав 2016, 247). Баярын явдал таарвал тэнгэр ивээлээ гэж сүсэглэн залбирч зовлон таарвал тэнгэр өршөө гэж хорчин ардын аман аялгууд “тэнгэр аав” гэж сүсэглэн даатгадаг.

Хорчин Зүүн гарын хойд хошууны хур гуйх тэнгэрийн тахилгаас үзвэл: хур бороо багатай жилд хорчин монголчууд тэнгэр “ааваа” гуйдаг байжээ. Улаанаар тахиж гэж бөө залж нэгэн бүдүүн овоо босгон гадуур нь есөн бага овоо босгон бүдүүн овоо дээрээ нэг Шэн (一升一斗 хятад хэмжүүр үг) хар будаа тальбин 9 бага овоон дээр таван өнгийн хуарыг ес ес хатгана. Хонь буюу үхрийн мах чанаад том аяганд хийж их овоо дээр тальбина. Жимсний зүйлсийг есөн бага овоо дээр тальбин, хундага архийг том овооны өмнө тальбин бүгдээрээ мөргөн даатгадаг (Боржигон Гомбожав 2016, 247) гэжээ. Харин доктор Д.Тангад “Тэнгэр өөд хүрз харуулах” гэсэн нийтлэг бус домын тухай “Эл дом нь: Бороо хур орохгүй, газар дэлхий гандаж гундахад тэнгэр өөд хүрзний ир харуулан ишээр нь газарт хатгадаг. Монгол дом үүслийн явцад төмрөөр аж ахуйн зориулалтаар зэр зэвсэг үйлдвэрлэн нэлээдгүй зан үйлд хэрэглэж ирсний нэг нь энэ юм” (Тангад 2020, 44) гэжээ. Хур бороо гуйхтай холбогдсон домоос үзэхэд хэрэглэгдэхүүн болон шившлэгүүд нь өөрийн өөрийн онцлогтой байх ба хорчины зан үйл нь овоо тахилгын шинжтэй, доктор Д.Тангадын судалсан дом нь хорчины хуй салхины домтой эртэй мэс хэрэглэж буйгаараа хэрэглэгдэхүүний төстэй байна.

### Дүгнэлт

Хорчин монголчуудын дом шившлэгийн хэрэглээний өнөөгийн байдалд (Жигүүртэн болон тэнгэр аргадахуйд холбогдох домын жишээнд) этнопоэтик онолын “диалогийн арга”, анкет асуулгын аргыг хослуулж хээрийн судалгаа хийж дараах дүгнэлтэд хүрлээ.

- Хорчин монголчуудын дунд монгол домын соёлын талаарх товч ойлголт, түүний хэрэглээний талаар 354 хүний дунд судалгаа хийж үр дүнг дүгнэж үзвэл энэ талаарх ойлголт 15-34 насны залуучуудын дунд тун тааруу байна гэж үзэв.
- Хошуу, гацаанд хийсэн хээрийн судалгааны үр дүнд мартагдан гээгдэж буй domuудыг бичвэр хэлбэрт оруулан хээрийн судалгааны тайлан бэлдэж судалгааны эх хэрэглэгдэхүүн болгосон нь ач холбогдолтой бөгөөд үнэ цэнтэй зүйл боллоо гэж үзэв.
- Хорчин монголчуудын дом шившлэгийн онцлогийг жигүүртэн болон тэнгэр аргадахуйд холбогдох домын хэрэглээний өнөөгийн байдалд тандалт судалгаа хийхэд онцлог зүйлүүд нэлээд байх ба хэрэглэгдэхүүн нь өөр өөр байв.



- Хорчины онцлог бүхий дом шивлэгийн эд хэрэглэгдэхүүн ба нутгийн аялгуу, соёл хоорондын харилцааны ижилсэх, ондооших, уусах үзэгдлүүд ажиглагдаж байгаа нь харь үгийн хэрэглээ тухайлбал, манж, хятад үгийг хольж өөриймшүүлэн хэрэглэж байгаа зэргээс харагдаж байна.
- Хорчин монголчуудын дом шившлэгийн хэрэглээ нь төв суурин газраа мартагдаж, орон нутагт ардын санаа сэтгэлд үлдсэн тэрхүү ой санамжуудыг сэргээн сануулж, тэмдэглэн баримтжуулах нь нэгэн хүний бус нийт хорчин түмний төдийгүй өвөрлөгч зоны хийх ёстой судалгааны орон зайн асуудал мөн болохыг дурдах нь зүйтэй байна.

### Ашигласан материал

- Боржигон Гомбожав. 2016. *Хорчин ардын уламжлалт зан үйлийн товчоо*. Хөх хот: Өвөр монголын хэвлэлийн бүлэглэл.
- Бямбарагчаа, Г. 2015. *Аман түүхийг сэргээх нь*. Улаанбаатар.
- Зоригт, Б., Ү Пү Ин, Боржигон Сайнбаяр, Чин Хуа, Асхан. 2017. *Хорчин агнал соёлын судлал*. Хөх хот: Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.
- Өлзий-Очир. 2021. *Өвөр монголын биет бус соёлын өв тэмдэг цуврал бичиг. Хорчин зүүн гарын хойд хошууны боть*. Чифен: Өвөр монголын шинжлэх ухааны хэвлэлийн хороо.
- Сампилдэндэв, Х. 1987. *Монгол ардын зан үйлийн аман зохиол*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн үйлдвэр.
- Тангад, Д. 2020. *Монгол домын тайлбар толь*. Улаанбаатар: Сэлэнгэ пресс.
- Хорлоо, П. 2004. *Монгол аман зохиол дахь түүхийн эх сурвалж*. Улаанбаатар: Бемби сан.
- Хүрэлшаа. 2012. *Хүрээ андай товчоо*. Хөх хот: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.
- Хүрэлшаа, Зоригт, Байган, Буянтогтох, Эрдэнхуяг, Гуа. 2005. *Хорчин зан үйл*. Хөх хот: Өвөр монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.
- Яан Баяр. 2005. *Монгол аман зохиолын үндсэн төрөл зүйл ба морины дүрийн тухай соёл зүйн судлал*. Хөх хот: Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Хавсралт

Хүснэгт 1. Эл өгүүлэлд дурдагдсан нутгийн аялгуу, манж, хятад үгийн тайлбар

| Дуудлага      | Гадаад үгийн дуудлага | Тайлбар                                                                            |
|---------------|-----------------------|------------------------------------------------------------------------------------|
| Адар          | 房顶 fangding           | Байшин гэрийн орой буюу дээвэр                                                     |
| Анга          | angai                 | Хүүхдийг энхэрийлэн, өнхөөрдөн дуудах                                              |
| Авгай жээ жээ | 姑姑 gugu               | Аавын охин дүү                                                                     |
| Голоо         | 乖乖 guai               | Өөрөөсөө насаах дүүмэд хүнийг элгэмсүү байдлаар хандахад хэлдэг үг                 |
| Мөөмөө        | 妈妈 mama               | Ээж                                                                                |
| Үү            | 痞 wu                  | Хар толов, жижиг ургацаг                                                           |
| Хуар          | 花 hua                 | Цэцэг                                                                              |
| Худуу         | 糊涂 hutu               | Тэнэг мунхаг                                                                       |
| Шаага         | 噶啦哈 galaha            | Шагай                                                                              |
| Тэнгэр аав    | 老天爷 laotianye         | Хүрээ хошууны монголчууд хүмүүсийг хүндлэх бас энэ аав чинь гэж ярьдаг хэрэглэдэг. |
| Жээ жээ       | 姐姐 jiejie             | эгч                                                                                |

Хүснэгт 2. Хорчины домын шившлэгт орсон хэрэглэгдэхүүний тайлбар

| Хорчин нутгийн хэллэг | Хятад хэллэг | Утга                         | Тайлбар                                                                                                      | Зураг                                                                                |
|-----------------------|--------------|------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------|
| Шэн                   | 升 sheng      | Тариалангийн хэмжүүр         | Эрт үед хүмүүсийн тариа будаа хийдэг сав байсан нь хожим нь худалдаа хийхэд зориулсан хэмжүүрийн сав болжээ. |   |
| Заадуу                | 闸刀 zhadao    | Тариалангийн багаж, хэрэгсэл | Өвс хэрчих зориулалт бүхий заазуур маягийн хутга.                                                            |  |
| Боодуу                | 宝刀 baodao    | Хоол хийх багж хэрэгсэл      | Ахуйн хэрэглээний эд ч гэсэн домын шившлэгт ордог.                                                           |  |
| Сандуу                | 山刀 sandao    | Тариа тарих багж хэрэгсэл    | Өвсний хадуур                                                                                                |  |